

“Z Үеийхний Суралцах Арга Барилыг Тодорхойлох нь

А.Буяндэлгэр

Мандах их сургууль, Нягтлан бодох бүртгэл Статистик 3-р түвшин оюутан
buyndelger.aagii17@gmail.com

Хураангуй: Дэлхий нийтэд *gen”z”*-ийн үеийхэн гэж ярьцгаах болсон билээ. Энэ үеийхний хамгийн гол онцлог нь богино хугацаанд суралцах хүсэл эрмэлзэлтэй, том амбицтай байх явдал юм. Дэлхийн 1/3 –ийг эзэлж буй эдгээр насны хүмүүсийн суралцах арга барилыг танин мэдсэнээр сурахуйн процесс илүү хялбар болох юм. Z үеийхний төлөөлөл болсон “Мандах” их сургуулийн оюутнуудаар хүрээллээ тогтоосон. Манай судалгаанд нийт 299 оюутан хамрагдсан бөгөөд оролцогчдын 80.9% эмэгтэй байсан. Хамгийн масс өндөртэй хөтөлбөр нь “НББ-Статистик” хөтөлбөрийн 70 оюутан оролцосон бол ИЭЗ ангиас 9 оюутан тус тус хамрагджээ. Мөн нэтгэсэн дүнгээр 3-р курсыхан 39.1% -ийг эзэлж байгаа бол 2-р курсыхан 11% -ийг тус тус эзэлж байна. Судалгааны үр дүнд сонсох хэв маяг 34.4%, 35.8% нь харах хэв маяг, 29.4% нь идэвхтэй хэв маягтай тус тус гарсан. Ингэснээр судалгааны Н1,Н2 таамаглал дэмжигдсэн.

Түлхүүр үг: z үеийхэн, суралцах үйл явц, суралцах хэв маяг

1. УДИРТГАЛ

Нийт 3 суралцах арга барилыг тодорхойлдог арга зүйг гаргаж ирсэн.Үүнд:

- “**Honey and Mumford**” хэв маяг- Петер Хонэе, Алан Мумфорд нар үндэслэсэн бөгөөд идэвхтэй хэв маяг, онолч хэв маяг, практикт хэв маяг, ургуулан бодогч хэв маяг гэсэн 4 хэв маягийг асуулгын хуудасын тусламжтайгаар тодорхойлж, тохиромжтой дадлага ажлуудыг санал болгодог./PeterHoney.com/
- “**RHEAA**” буюу Пенсалваны ерөнхий Ассемблегаас бэлтгэн гаргасан бөгөөд нийт 20 асуулгаар сонсон хэв маяг, харах хэв маяг, идэвхтэй хэв маяг гэсэн нийт 3 суралцах арга барилыг тодорхойлж, тохиромжит хийж болох энгийн дадлага ажлыг бэлтгэн харуулдаг./educationplanner.org/
- “**Filder-Silverman**”-ний суралцах хэв маягийн модел- эргэцүүлсэн идэвхтэй хэв маяг,зөн билгийн хэв маяг, харах гэсэн 3 хэв маягийг тодорхойлдог. Гол онцлог нь багш, суралцагч 2-ыг хамтад нь авч үздэг.

Эдгээрээс би 2 дахь арга зүйг ашиглан судалгаагаа хийсэн. Учир нь стандарт асуулгын асуултууд маш энгийн, сонирхолтой, судалгаанд оролцогчдыг уйдаахааргүй асуултууд байсан ба 1963 оноос хэрэгжиж буй арга зүй учир илүү нотолгоотой гэж үзсэн.

1.1. Зорилго

“Z” үеийхний төлөөлөл болсон “мандах” их сургуулийн оюутануудын суралцах арга барил нь бусад үеийхээс илүү ялгаатай гэдгийг онолоор дэмжин харуулж, түүнийг эх олонлогийг төлөөлж чадах түүврийн хэмжээнд судалгаа авч нотлон, цаашид тохирох заах арга барил хийгээд суралцах арга барилын зохимжит санал зөвлөмжийг хүргэхэд оршино.

1.2. Зорилт

Анкетын аргаар судалгаа авах, судалгаанд хамрагдсан оюутнуудын суралцах хэв маягийг тодорхойлох

1.3. Судалгааны объект:

“Мандах” их сургуулийн төв салбар дахьоюутнууд

1.4. Судалгааны таамаглал

Н1: Z үеийхний сурах үйл явцад харах, сонсох, идэвтэй байдал нь ялгаатай.

Н2: Z үеийхний сурах арга барил курсын хувьд ялгаатай.

1.5. Түүврийн оновчтой хэмжээ

Судалгаандаа энгийн санамсаргүй түүврийн аргаар түүврийн хэмжээгээ тодорхойлсон. Томьёоллыг доор үзүүлэв:

$$n = \frac{t^2 * w * (1 - w) * N}{N * \Delta_p^2 + t^2 * w * (1 - w)}$$

Хүснэгт 1.

Өгөгдөл	Утга	тайлбар
t	1.96	95%-ийн итгэх магадлалын түвшин
w	0.5	Тогтмол утга
N	1361	Эх олонлог /Мандах их сургуулийн төв салбар дахь оюутны тоо/
	0.05	Алдааны хязгаар
n	299	Оновчтой түүврийн хэмжээ

2. СУДЛАГДСАН БАЙДАЛ

- 2016 онд Олон улсын сувилагчдын зөвлөлөөс гаргасан “сувилагчийн төгсөх ангийн оюутнууд дахь VAK /харах, сонсох, идэвхтэй хэв маяг/ суралцах арга барилд хийсэн үнэлгээ” судалгааны бүтээлд миний судалгаандаа ашиглаж буй арга зүйгээр судалгаагаа хийжээ. Товч танилцуулахад нийт 2 их сургуулиас 210 оюутанг түүврийн аргаар судалгаа аван суралцах 3 хэв маягийг хувиалан тодорхойлсон. Үр дүнд нь суралцагчдын 40.3% нь сонсох хэв маягтай гэж гарсан бөгөөд гол дэвшүүлж буй асуудал нь зааж буй багш нар нь суралцагчид тохирсон хэв маягийг мэдэж байх чухал гэсэн агуулга байсан.
- Касетарт их сургуулиас бэлтгэн гаргасан судалгаа нь нийт 6 суралцах арга барилыг тодорхойлж хэл суралцах процессийг лавшруулан үзсэн. Нийт 262 Тайланд оюутан оролцуулсан бөгөөд судалгааны үр дүнд 6 хэв маягт тохирох суралцах талбаруудыг сонгосон. Үүнд газар тариалан дээр 92 оюутан, спорт дээр 12 оюутан гэх мэтчилэнгээр хувааж үзсэнээр хэл сурах үйл явцыг түргэвчилнэ гэсэн дүгнэлтэнд хүрчээ.
- Монгол дахь судалгааг авч үзвэл: БС-ын хөтөлбөрийн ахлах доктор М.Азжаргал, ахлах багш Ч.Сувд-эрдэнэ нарын “Сургалтанд сурах хэв маягийг ашиглах нь” судалгааны бүтээлд 74 оюутанг хамруулсан бөгөөд дэвшүүлж буй зорилго нь амжилттай суралцах гэдэгт зөвхөн хувь хүний чармайлтаас гадна орчин, сургагч багш нар сурагч бүрийн хэв маягийг мэддэг байх нь суралцагчийн амжилтанд нөлөөлнө хэмээн үзжээ.

3. ОНОЛЫН СУДАЛГАА

Судлаачид, зохиолчид олон жилийн туршид янз бүрийн шалгуурыг ашиглаж, өөр өөр үеийхний хил хязгаарыг тогтоосон байдаг.

Үе үе хуваарилагдсан цаг хугацаа нь ихэвчлэн 15-20 жилийн хугацаатай байдаг бөгөөд хүн ам зүй, түүхэн үйл явдал, судлаачдын дундах зөвшилцөл, цаг үе, шинэ техник технологи, хувийн үзэл баримтлал, суралцах арга зүй, боловсрол, итгэл үнэмшил, карьер төлөвлөлт, гэр бүлийн амьдрал, улс төрийн чиг хандлага гэх мэт олон хүчин зүйлээс хамаарч тодорхойлогдох болон ангилагддаг.

АНУ-ын Вашингтон дахь “Pew” судалгааны төвөөс дараах ангилалыг гаргасан байдаг. Үүнд:

- Silent generation** буюу чимээгүй үеийхэн 1928-1945 онуудад төрөгсөд ба суралцах хэв маяг нь албан боловсрол байв.
- Boom generation** буюу их төрөлтийн үе 1946-1960 онуудад төрөгсөд бөгөөд тодорхой бүтэцэд баригдсан хэлбэрээр суралцдаг байсан.
- X generation** буюу экс үеийхэн гэж нэрлэгдэх 1960-1980 онуудад төрсөн хүмүүс юм. Суралцах хэв маяг нь оролцоог хангахад чиглэгдэж эхэлсэн.
- Y generation** (millennial generation) буюу шинэ мянганыхан гэж нэрлэгдэх 1980-1998 онуудад төрөгсөд юм. Суралцах хэв маяг нь төсөөлөлд суурилдаг.
- Z generation** буюу шинэ мянганыхны дараа үеийхэн гэж нэрлэгдэх 1998-2012 онуудад

төрсөн хүмүүсийг хамааруулна. Суралцах хэв маяг нь технологит суурилсан байдаг.

6. **Альфа үеийхэн**-2012 оноос хойш төрөгсөд бөгөөд суралцах хэв маяг нь илүү даяаршиж, цахим туслахуудад суурилж эхэлжээ.

4. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

Тайлбар: Энэхүү судалгаагаа educationplanner.org албан ёсны сайтын суралцах арга барилыг тодорхойлох үндсэн 20 стандарт асуулт бүхий асуулгыг/ энэхүү асуулга нь сонсох, харах, идэвхтэй гэсэн үндсэн 3 хэв маягийг тодорхойлж өгдөг/ нийт 299 оюутанаас авч судалгааны нэгтгэлийг SPSS программ дээр боловсрууллаа. Ингэхдээ оюутнуудын анги, курс, хүйс, суралцах хэв маяг гэж үндсэн 4 багц болгон нэгтгэсэн. Судалгаанд хамрагдсан оюутануудын хүйсийн хувьд: 80,9% нь эмэгтэй, 19,1% нь эрэгтэй оюутнууд байна.

Хүснэгт 2. Таны хүйс?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Эр	57	19.1	19.1	19.1
	Эм	242	80.9	80.9	100.0
	Total	299	100.0	100.0	

Судалгаанд 36.8% нь 1-р курс, 11% нь 2-р курс, 39.1% нь 3-р курс, 13% нь 4-р курс бүхийнийг эх олонлогийг төлөөлж чадах 299 оюутан оролцсон.

Хүснэгт 3. Та хэддүгээр курс вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	1-р курс	110	36.8	36.8	36.8
	2-р курс	33	11	11	47.8
	3-р курс	117	39.1	39.1	87
	4-р курс	39	13	13	100
	Total	299	100	100	

Судалгаанд нийт 9 хөтөлбөрийн оюутнууд хамрагдсан бөгөөд тус бүрийн хамрагдсан оюутнуудын тоог доорхи хүснэгтэнд харуулав.

Хүснэгт 4. Та ямар ангид суралцдаг вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	НББ-Статистик	70	23.4	23.4	23.4
	НББ-Аудит	29	9.7	9.7	33.1
	Санхүүгийн менежмент	19	6.4	6.4	39.5
	НББ-Татвар	42	14.0	14.0	53.5
	НББ-Банк	37	12.4	12.4	65.9
	Мэдээллийн систем	14	4.7	4.7	70.6
	НББ-Англи хэл	47	15.7	15.7	86.3
	Инженер эдийн засаг	9	3.0	3.0	89.3
	Банкны менежмент	32	10.7	10.7	100.0
	Total	299	100.0	100.0	

Хүснэгт 5. Суралцах хэв маяг?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Сонсох хэв маяг	103	34.4	34.4	34.4
	Харах хэв маяг	107	35.8	35.8	70.2
	Идэвхтэй хэв маяг	88	29.4	29.4	99.7
	11.00	1	.3	.3	100.0
	Total	299	100.0	100.0	

5. ҮР ДҮН

Нийт дүнгээр сонсох хэв маяг 34.4%, харах хэв маяг 35.8%, идэвхтэй хэв маяг 29.4% гарсан нь “Н1: Z үеийхний сурах үйл явцад харах, сонсох, идэвтэй байдал нь ялгаатай” гэсэн таамаглал дэмжигдэж байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 6.

Суралцах хэв маяг?			Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Сонсох хэв маяг	Valid	1-р курс	36	35.0	35.0	35.0
		2-р курс	14	13.6	13.6	48.0
		3-р курс	42	40.8	40.8	89.0
		4-р курс	11	10.7	10.7	100.0
		Total	103	100.0	100.0	
Харах хэв маяг	Valid	1-р курс	39	36.4	36.4	36.4
		2-р курс	11	10.3	10.3	46.7
		3-р курс	43	40.2	40.2	86.9
		4-р курс	14	13.1	13.1	100.0
		Total	107	100.0	100.0	
Идэвхтэй хэв маяг	Valid	1-р курс	35	39.8	39.8	39.8
		2-р курс	8	9.1	9.1	48.9
		3-р курс	32	36.4	36.4	85.3
		4-р курс	13	14.8	14.8	100.0
		Total	88	100.0	100.0	
11.00	Valid	4-р курс	1	100.0	100.0	100.0

Үр дүн: хөтөлбөр харгалзахгүйгээр авч үзвэл 1-р курсыхны 35% нь сонсох хэв маягтай, 36.4% нь харах хэв маягтай, байгаа бол 2-р курсыхны хувьд 13.6% нь сонсох хэв маягтай, 10.3% нь харах хэв маягтай байна, 3-р курсыхны хувьд 36.4% нь идэвхтэй хэв маягтай, 40.2% нь харах хэв маягтай байна, 4-р курсыхны хувьд 14.8% нь идэвхтэй хэв маягтай бол 13.1% нь харах хэв маягтай байна. Эндээс харахад миний дэвшүүлсэн Н2 таамаглал дэмжигдэж байна.

6. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны гол зорилго нь “Мандах” их сургуулийн Z үеийхний төлөөлөл яг ямар суралцах арга барилтай вэ гэдгийг тодорхойлж тэрхүү суралцах арга барилд тохирсонмөн Z үеийхний онцлогт тохируулан өөрийн зүгээс санал зөвлөмжийг гаргаж ирэхэд оршсон билээ.

Судалгааг Z үеийхний төлөөлөл “Мандах” их сургуулийн төв салбарт суралцаж буй оюутнуудаар судалгаан хүрээгээ сонгосон бөгөөд нийт эх олонлогийг төлөөлж чадахуйц түүврийн хэмжээг сонгон авч, educationplanner.org сайтын стандар 20 асуулгаар нийт оролцогчдын суралцах хэв маягийг тодорхойлж Н1: Z үеийхний сурах үйл явцад харах, сонсох, идэвтэй байдал нь ялгаатай Н2: Z үеийхний сурах үйл явцад курсын хөтөлбөрийн хувьд ялгаатай гэсэн 2 таамаглалыг дэвшүүлсэн бөгөөд Н1,Н2 таамаглал судалгааны үр дүнд дэмжигдсэн.

Судалгааны үр дүн: судалгаанд 19.1% нь эрэгтэй, 80.9% эмэгтэй оюутан тус тусхамрагдсан. Мөн 36.8% нь 1-р курс, 11% нь 2-р курс, 39.1% нь 3-р курс, 13% нь 4-р курсын оюутнууд оролцсон. 23.4% нь НББ-Статистик хөтөлбөр, 9.7% нь НББ-Аудит, 6.4% нь Санхүүгийн менежмент, 14% нь НББ-Татвар, 12.4% нь НББ-Банк, 4.7% нь Мэдээллийн систем,15.7% нь НББ-Англи хэл, 3% нь Инженер эдийн засаг,10.7% нь Банкны менежмент хөтөлбөрийн оюутнууд тус тус хувийг эзэлсэн. Нийт дүнгээр, сонсох хэв маяг 34.4%, 35.8% ньхарах хэв маяг, 29.4% нь идэвхтэй хэв маягтай тус тус гарч ирсэн нь Н1 таамаглал болох Z үеийхний сурах арга үйл явцад харах, сонсох, идэвхтэй байдал ялгаатай байгаа нь дэмжигдэж байна. Сонсох хэв маягт 1-р курс 35%, 2-р курс 13.6%, 3-р курс 40.8%, 4-р курс 10.7% тай байсан бол харах хэв маягийн хувьд 1-р курс 36.4%, 2-р курс 10.3%, 3-р курс 40.2%, 4-р курс 13.1% эзэлсэн ба идэвхтэй хэв маяг нь 1-р курсын хувьд 39.8%, 2-р курс 9.1%, 3-р курс 36.4%, 4-р курс 14.8% тус

тус байна. Эндээс үзэхэд миний дэвшүүлсэн H2 таамаглал болох Z үеийхний суралцах арга барил курсын хувьд ялгаатай нь дэмжигдэж байна.

7. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүн сонсох хэв маяг 34.4%, 35.8% нь харах хэв маяг, 29.4% нь идэвхтэй хэв маягтай тус тус гарлаа. Тиймээс “Сургалтанд сурах хэв маягийг ашиглах нь”судалгааны бүтээлд дурдсанаар:

- сонсох арга барилтай 34.4 % оюутнуудад технологи дээр суурилсан богинохэмжээний сонсголын дасгал, харилцан ярианы дасгал тохиромжтой.
- харах арга барилтай 35.8% оюутнуудад дижитал төхөөрөмж ашиглан үзүүлэн бэлтгэх, унших материал бэлтгэх нь тохиромжтой.
- идэвхтэй арга барилтай 29.4% оюутнуудад хөдөлгөөн шаардсан жүжигчилсэнтгоглолт идэвх шаардсан дасгал ажил тохиромжтой юм.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

- [1] Academia.edu.mn
- [2] 1212.mn
- [3] CDIO 2013 оны хурлын эмхэтгэл
- [4] Erdenetis.edu.mn
- [5] Visioncritical.com
- [6] Eduhelp.mn
- [7] Идэвхтэй сургалтын арга зүй гарын авлага 2015
- [8] Доктор М.Азжаргал, Доктор Ч.Сувд-эрдэнэ “Сургалтанд сурах хэв маягийг ашиглахнь” /он тодорхойгүй/
- [9] Chili Li (2012) “An Investigation of Chinese Learning Styles at an English-medium University in Mainland China”
- [10] Rajshree S. Vaishnav “Learning Style And Academic Achievement Of Secondary School Students”
- [11] R. Jurenka1, A. Stare Ek1, N. Vra Aková1 D. Cagá Ovál” The Learning Styles of the Generation Group Z and Their Influence on Learning Results in the Learning Proces